

Орон - Бүхний пролетариат нар нэгдэвч!

АНХ ДУГААР ТАВАН ЖИЛ

Төв аймгийн Намын Хороо, АДХ-ын гүйцэтгэх захиргааны сонин

27 дахь жилдээ № 56 (2320) 1974 оны 7 дугаар сарын 26 БААСАН

НООС БЭЛТГЭЛТ, ТЭЭВЭРЛЭЛТИЙН АЖЛЫГ ШУУРХАЙ ДУУСГАЯ

Бүх ард түмний социалист уралдааны шийдвэрлэгч жилийн төлөвлөгөөт зорилтыг нэг хэсэг, төрөл бүрийн манай ноосыг цаг хугацаанд нь хангалдгүй цэвэр авч тушаах нь үйлдвэр экспортын хэрэгцээг хангах чухал ач холбогдолтой юм. Манай аймгийн ХАА-н нэгдэл, САА, худалдаа бэлтгэлийн байгууллага 1974 онд 1547,7 тонн төрөл бүрийн ноос улсын бэлтгэлд нийлүүлэхээс одоогийн байдлаар 988,4 тонн ноос бэлтгээд байна. Гэвч тэмээ, ямааны ноос бодын хөөвөр хялгас бэлтгэх хугацаа өнгөрөөд байхад 79,4—92,3 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь орон нутгийн нам, улс ХАА, ХБ-ийн зарим байгууллагуудаас энэ ажилд хариуцлага санаачлага муутай хандаж цаг алдаж байгаа ноштой дутагдал мөн. Бүх төрлийн ноос бэлтгэх ажлаар Эрдэнэ, Бүрэн, Мөнгөнморьт Эрдэнэсант сумд сүүлчийн байранд явна. Ноос бэлтгэлийн ажилд орон нутгийн худалдаа бэлтгэл, ХАА-н байгууллага бэлтгэл зохион байгуулалт хяналт шалгалтыг сулруулснаас цаг хугацаа ихээхэн алдаж байна. Иймд малчинд хөдөлмөрдлийг идэвхи санаачлага чармайлыг ор нүүлэн гүйцэтгэлийн хяналт шалгалтыг тогтмолжуулж төлөвлөгөөт зорилтыг ханган биелүүлэхэд ХАА, ХБ-ийн бүх байгууллага анхаарал санаачлага дайчлах хэрэгтэй юм. Алд бригад, тасаг, суурийн ноос бэлтгэл хоноцор байгааг шалган үзэж бэлтгэлийн дутууг биелүүлэх ажлыг тэр нэгж хэсгээс эхлэвэл зохино. ХБ-ийн анги малчдын бэлтгэсэн ноосыг үлдсэн авч түргэн тээвэрлэх, үйлдвэр баазад тушаах ноосны чанарыг ахиулахын тулд суурь, айл орхууд төрөл өнгөөр нь ялган цэвэрлэх, бороо уснаас хамгаалах зэрэгт хяналт тавих шаардлагатай байна. Бэлтгэсэн ноосыг зохих хугацаанд нь эх орны үйлдвэр, экспортын баазад тушаахгүй удааширнаас 1973 онд зарим сумдын ХБ-ийн ангид ихээхэн хэмжээний ноос он дамжин үлдэгдэл болж байв. Энэ явдал үйлдвэр экспортын хэрэгцээг цаг тухайд нь хангахад муугаар нөлөөлж байгааг тээврийн байгууллага онцгой анхаарах нь чухал. Бэлтгэж цуглуулсан бүх төрлийн ноосыг тухай бүрт нь тээвэрлэж намрын хадлан тарна хураах зэрэг кампанит ажлын өмнө дуусгах явдал тээврийн байгууллага нийт тээвэрчдийн хойшлуулшгүй зорилт болж байна.

Нэгэнт бэлтгэгдээд тушаагдсан ноосыг преслэж машины даац ашигдалтыг сайжруулах явдалд нийт ХБ-ийн анги онцлон анхаарч бэлтгэгдсэн бүх ноосыг преслэх явдал чухал байна. Манай зарим сумдын ХБ-ийн анги ноосныхоо үлдэгдлийг бэлтгэлийн график мэдээндээ бичиггүй байж их үлдэгдэлтэй гэсэн буруу мэдээ судалгаа гаргадаг явдлыг дахин давтаж болохгүй. Бэлтгэлийн зүйл тээвэрлүүлэхээр байгуулсан аж ахуйн гэрээгээ тээврийг удирдах газартай ХБУ газар үе үе дүгнэж шаардагдах арга хэмжээг авч байвал зохино. Энэ оны төрөл бүрийн ноос бэлтгэлийн төлөвлөгөөг хугацаанд нь бүрэн биелүүлж түүнийг түргэн тээвэрлэж дуусгах нь ХАА, ХБ-ийн нийт байгууллагын анхаарлын төвд байх ёстой.

Сумын ХБ-ийн ангид 1974 оны эхний хагас жилийн худалдаа бэлтгэлийн төлөвлөгөөт ажил, социалист уралдаанд авсан үүргийн биелэлтээр байр эзлүүлсэн дүн

Сумын нэр	Эзлэх байр	Баянцогт
Батсүмбэр	1	Өндөрширээт
Сэрлэн	2	Эрдэнэ
Баянзүрх	3	Баян-өнжүүл
Баянцагаан	4	Баянчандмань
Баянжаргалан	5	Дэлгэрхаан
Борнуур	6	Зуунмод
Жаргалант	7	Лүн
Эрдэнэсант	8	Баяндэлгэр
Угтаал	9	Алтанбулаг
Заамар	10	Бүрэн
Мөнгөнморьт	11	Баян
		ХБУГ-ын уралдааны комисс

Хадлан тэнжээл бэлтгэх ажилд тэргүүний амжилт гаргасан сум, нэгдэл, САА, хороо, захиргаа, тэнжээлийн аж ахуй, ферм, бригадуудыг шалгаруулах уралдааны БОЛЗОЛ

Малын тэнжээл бэлтгэх ажилд бүх нийтийн хүнийг чиглүүлэн, хадлан бэлтгэх ажлыг богино хугацаанд чанартай явуулж дуусгах зорилгоор сум нэгдэл, сум-САА, хороо, захиргаа, тэнжээлийн аж ахуй ферм бригадуудыг шалгаруулж дүгнэх социалист уралдааны болзлыг зарлаж байна.

Нэг. Болзлыг шалгаруулах үндсэн үзүүлэлт

Хадлангийн төлөвлөгөө биелүүлсэн байх доод хэмжээ	VIII-10	VIII-20	IX-1
Дүгнэх хугацаа	30%	70%	101%
Сум нэгдэл			
Сум-САА, ТАА, хороо, захиргаад	40%	80%	105%

Хоёр. Болзол дүгнэхэд харгалзах үзүүлэлтүүд

1. Бригад ферм, суурь, өрх бүрд хадах өвсний төлөвлөгөө, даалгавар гардуулан, социалист уралдаанд амлалт үүрэг авч ахуй сум хороодоос, хадлангийн бригад салаадыг 3—5 хоног, бригад, фермээс хадланчдын ажлыг өдөр бүр дүгнэж байр эзлүүлсэн байх
2. Хадланчдыг соёл ахуйн үйлчилгээ, хадлангийн багаж, тоног төхөөрөмж зүтгэх хүчээр бүрэн хангасан байх.
3. Бэлтгэсэн хадланг ялзаруулж чанарыг муутгаагүй, 8-р сарын 20-доор сум хороод хадсан өвснийхээ 60 хувь, бригад ферм 70 хувийг 9-р сарын 1-нээр сум хороод 80 хувь бригад ферм 90 хувийг өвөлжөө, хаваржаа, бригад, суурийн дундын фондод татаж хамгаалсан байх.
4. Даршны ургамлыг хугацаанд нь чанартай хурааж даршласан байх.
5. Үйлдвэрлэлтэй холбогдсон осол гэмтэл гаргаагүй байна.
6. Хадлангийн мэдээг бригад, салаа, суманд, сум хороод аймагт графикт хугацаанд нь тогтмол үнэн зөв гаргаж байх.

Гурав. Болзлыг шалгаруулах журам, хугацаа шагнал

1. Хадлангийн явцад: Энэхүү болзлыг дээрхи хугацаанд 3 удаа дүгнэж, хадлангийн төлөвлөгөөг болзолд заасан хэмжээ нээс доошгүй хувиар биелүүлсэн, сум хороод, сангийн аж ахуй, тэнжээлийн аж ахуйнуудыг харгалзах үзүүлэлтүүдээр шалгаруулан байр эзлүүлж шагнана.

Эзлэх байр түүний тоо

1-р байр	1. 350 төгрөг
Дүгнэх хугацаа	Аймгийн Намын хороо, АДХ-ын гүйцэтгэх захиргаа, УЭ-ийн зөвлөл, ХЗЭ-ийн хорооны диплом
VIII-10	2-р байр 1. 250 төгрөг
	Аймгийн Намын хороо, АДХ-ын гүйцэтгэх захиргааны баярын бичиг
	3-р байр 1. 200 төгрөг
	Аймгийн Намын хороо, АДХ-ын гүйцэтгэх захиргааны баярын бичиг

1-р байр 1. 450 төгрөг
Аймгийн Намын хороо, АДХ-ын
Аймгийн Намын хороо
Үйлдвэрчний Эвлэлийн зөвлөл

СЕМИНАР БОЛОВ

Саяхан ХАА-н барилгажилтын аймгийн комиссоос эрхлэн ХАА-н барилгажуулалтын сумдын комиссын орлогч дарга, инженер, техникчид, барилгын бригадын дарга, хашаа худгийн бригадын дарга нарын 3 өдрийн семинарыг Зуунмод хотод хийлгэв. Семинарт МАХН-ын Төв Хорооны V бүгд хурлаас дэвшүүлсэн зорилт, барилгыг төлөвлөх санхүүжүүлэх журам, барилгын хөрөнгө оруулалт, анхан шатны бүртгэл тооцоо, эмчилгээ тэжээлийн цэгийг аж ахуйн талаар тохижуулах зэрэг сэдвээр 80 гаруй цагийн хичээл заав. Мөн ХАА-н барилгажилтын улсын комиссын орлогч дарга Дэмчигсүрэн оролцож үнэтэй зөвлөлтөө өгөв.

Н. ХАНДСҮРЭН

- гүйцэтгэх захиргаа, УЭ-ийн зөвлөл, ХЗЭ-ийн хороон диплом
- 2-р байр 1. 350 төгрөг
Аймгийн Намын хороо, АДХ-ын гүйцэтгэх захиргааны баярын бичиг
- 3-р байр 1. 300 төгрөг
Аймгийн Намын хороо, АДХ-ын гүйцэтгэх захиргааны баярын бичиг
- VIII-20
- 1-р байр 1. 800 төгрөг
Аймгийн Намын хороо, АДХ-ын гүйцэтгэх захиргаа, УЭ-ийн зөвлөл, ХЗЭ-ийн хорооны диплом
- 2-р байр 1. 600 төгрөг
Аймгийн Намын хороо, АДХ-ын гүйцэтгэх захиргааны баярын бичиг
- IX-1
- 3-р байр 1. 500 төгрөг
Аймгийн Намын хороо, АДХ-ын гүйцэтгэх захиргааны баярын бичиг

2. Хадлангийн эцэст:
 - а) САА, ТАА, ХАА-н нэгдлүүдийн ферм, бригадуудыг төлөвлөгөөний гүйцэтгэл, өвсний таталт хамгаалсан байдлаар цуваагаар байр эзлүүлэн, тэргүүний байр эзэлсэн ферм 1, бригад 1-ийг тус бүр 500 төгрөг, аймгийн Намын хороо, АДХ-ын гүйцэтгэх захиргаа, УЭ-ийн зөвлөл, ХЗЭ-ийн хорооны дипломоор;
 - б) Хадлангийн аварга хадланчин шалгаруулж аймгийн аваргын диплом мөнгөн шагналаар шагнана;
 - в) Хадлангийн хугацаанд сум нэгдлүүдийг хариуцан ажилласан албан үйлдвэрийн газруудыг дор дурьдсан үзүүлэлтээр шалгаруулан шагнана.

1. Хариуцсан сум нь:

- а) Хадлангийн хугацаанд энэхүү социалист уралдаанд 2-оос доошгүй удаа шалгарсан байх

- б) Хадлангийн төлөвлөгөөг 9-р сарын 1-ний дотор чанартай биелүүлсэн байх;

2. Хариуцсан сумынхаа хадлан, тэнжээлийн төлөвлөгөөг биелүүлэхэд аж ахуй, зохион байгуулалт, ажиллах хүч, тээвэр ахуй үйлчилгээний бодит туслалцаа үзүүлсэн байна.

3. Сумын хадлангийн төлөвлөгөөг хугацаанд нь биелүүлэхэд шийдвэрлэх нөлөө үзүүлэх удирдлага зохион байгуулалтын шинэ арга хэлбэрийг санаачлан ажилласан байна.

4. Сум хариуцсан албан үйлдвэрийн газрыг хадлангийн эцэст 1 удаа дүгнэж 1-р байр 1-д 500 төгрөг -Аймгийн Намын хороо, АДХ-ын гүйцэтгэх захиргаа, УЭ-ийн зөвлөл, ХЗЭ-ийн хорооны дипломоор
- 2-р байр 1-д 400 төгрөг -Аймгийн Намын хороо, АДХ-ын гүйцэтгэх захиргаа, УЭ-ийн зөвлөл, ХЗЭ-ийн хорооны баярын бичиг.
- 3-р байр 1-д 300 төгрөг -Аймгийн Намын хороо, АДХ-ын гүйцэтгэх захиргаа УЭ-ийн зөвлөл, ХЗЭ-ийн хорооны баярын бичиг

АДХ-ын гүйцэтгэх захиргаа
ХЗЭ-ийн хороо



ХАДЛАНГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ ДАВУУЛСАНД ОЛГОХ ШАГНАЛ

Хадлангийн бригад, салаа өгөгдсөн үйлдвэрлэлийн төлөвлөгөөг давуулан биелүүлбэл давуулж бэлтгэсэн өвсний борлуулалтын үнийн 15 хувиар бодож хадлангийн бригадын ажилчид, бригадын дарга, тоо бүртгэгч нарт үндсэн ба нэмэгдэл хөлсөн дээр нь шагнал олгоно. Жишээлбэл: Хадлангийн бригад 5000 тонн өвс бэлтгэх төлөвлөгөөг 300 тоннор давуулсан бөгөөд борлуулах үнэ нь тонн тутамд 150 төгрөг гэвэл 6750 төгрөг ($300 \times 150 \times 0,15$)-ийг шагналд олгоно. Хэрэв уг бригад хадлан өвс бэлтгэх төлөвлөгөөг 8 дугаар сарын 20-нд биелүүлчихвэл цаашид давуулан биелүүлэх шагналын хувийг 100 хувиар нэмэгдүүлж, төлөвлөгөө давуулсны шагналын 30 хувиар бодож олгоно.

Шагналын хэмжээ нь дээрхи жишээний адилаар бодоход 13500 төгрөг ($300 \times 150 \times 0,30$) болно. Төлөвлөгөө давуулсны шагналын мөнгийг бригадын дарга, тоо бүртгэгч ажилчдад жинхэнэ авсан үндсэн цалинтай нь шууд харьцаатайгаар урьдах жишээний адилаар хуваарилж олгоно.

Эдийн засагч Д. ЛХАГВА

УРАЛДААН ДҮГНЭВ

Төв, Өвөрхангай аймгийн хооронд 1974 онд байгуулсан социалист уралдааны эхний хагас жилийн дүнг Өвөрхангай аймгийн Бүрд сумын төвд гаргав. Уралдааныг 57

үзүүлэлтээр дүгнэхэд Өвөрхангай аймаг 17 үзүүлэлт, Төв аймаг 12 үзүүлэлт авч 28 үзүүлэлтээр тэнцэж Өвөрхангай аймаг түрүүлээ. Манай аймаг уралдаант Өвөрхан-

гай аймгаас хашаа барилт, худат гаргалт, бараа гүйлгээ, хонь, тэмээ, ямааны ноос, хөөвөр бэлтгэх талаар сүрхий хоцорч байгаад анхаарч төлөвлөгөөт үзүүлэлтийг нэр төрөл дээр нь жигд сайн биелүүлэх явдал шаар-

дагдаж байна. Оны эхний хагас жилд манай аймгийн ХАА, соёлын байгууллага, аж үйлдвэрийн газрууд уралдаант аймагаас илүү амжилт гаргасан байхад худалдаа, эрүүлийг хамгаалах байгууллагууд нэгээс дөрвөн

үзүүлэлтээр хоцорч байгаад зохих дүнгэлт хийж жилийн эцсийн уралдаанд түрүүлэхийн төлөө бүх ажлын уялдаа холбоог сайжруулж, нөөц бололцоогоо дайчлан ажиллах нь чухал байна.

П. ЖАНЧИВ

БҮРТГЭЛ ТООЦОО ХЯНАЛТ ШАЛГАЛТ

Улс ардын аж ахуйн эдийн засгийн албанд төлөвлөлт урамшууллын шинэ систем, шинжлэх ухааны үндэслэлтэй хөдөлмөр зохион байгуулалт, бүртгэлийн дэвшилт хэлбэр, журнал одерсийн болон төсвийн, газруудын дансны давхар систем, ХАА-н нэгдлүүдийн бүртгэл, тайланд шинэ журамд хэрэглэгдэж байгаа нь бүртгэл тооцооны ажил үйлдвэрлэлийн харилцааны хөгжлийн дагуу улам боловсронгуй болж байгаа явдал мөн.

Улс ардын аж ахуйн салбарууд дахь бүртгэлийн систем нь нийгмийн үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлэх, социалист аж ахуйг эдийн засгийн гүнзгий үндэстэй удирдан хөтлөхөд чиглэгдэх энэ чанараараа социализмын материал техникийн баазыг бэхжүүлэхэд чухал ач холбогдол үзүүлж бай-

на. Зөв сайн зохион байгуулагдсан бүртгэл нь улс ардын аж ахуй, соёлыг хөгжүүлэх талаар намаас дэвшүүлж тавьсан зорилт, төлөвлөгөөт даалгаврын биелэлтэнд гүйцэтгэлийн хяналт шалгалт хийж улс, хоршоол, үйлдвэр аж ахуйн газрын үйл ажиллагааг үр ашгийг зохион байгуулж удирдах, социалист өмч хөрөнгийг нэмэгдүүлэн зөв хуваарилж, гамтай зарцуулах, дотоод нөөц бололцоог илрүүлэн дайчлах чухал хэрэгшүүр болно.

Нийгмийн үйлдвэрлэл, бүтээгдэхүүний хуваарилалт, хэрэглээ, албан апаратын болон хүмүүсийн үйл ажиллагаанд бүртгэл тайлан тооцоо, хяналт шалгалтыг тууштай нэвтрүүлэх нь ажил хэргийг алдаа мандаггүй хөнгөн шуурхай явуулан боловсон хүчнийг сурган хүмүүжүүлж улс нийгмийн хөгжлийг түр-

дэтгэхэд асар их ач холбогдолтой юм.

В. И. Ленин «Зөвлөлт засгийн ээлжит зорилт» зохиолдоо «Социализм бол бүртгэл тооцоо мөн», «Бүртгэлгүйгээр бүтээгдэхүүний үйлдвэрлэлт хуваарилалтыг зөв зохион байгуулан удирдаж чадахгүй, хөдөлмөрийн бүтээмж, сахилгаа батыг дээшлүүлж, социалист уралдааныг зөв зохино ажлыг хийж чадахгүй» гэж сургасан билээ.

Бүртгэл тооцоонд тавих хяналтыг сайжруулахад түүнийг эрхэлсэн байгууллага, хүмүүсээр зогсохгүй нам, эвлэл, олон нийт, хяналт шалгалтын байгууллагын нийт ажилтнууд идэвхтэй оролцож ихээхэн үрүрг гүйцэтгэж, ёстой. Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт Хэвлэх үйлдвэр, Харилцаа холбоо,

Эрүүлийг хамгаалах газар, Хүнсний комбинат зэрэг газруудад сайжирч, бүртгэл тооцооны тэргүүний байгууллагуудын эгнээнд хүрв.

Гэвч одоогийн байдлаар бүртгэл тооцооны хяналтыг сайжруулахад олонхи байгууллага олон түмнийг идэвхтэй оролцуулж чадахгүй байна.

Анхан шатны бүртгэл зохих ёсоор хөтлөгдөхгүй, тооллого, тооцооны чанар муу байгаагаас худалдаа бэлтгэлийн байгууллагууд, ХАА-н нэгдлүүдэд нийгмийн өмч хөрөнгө үрэгдэх явдал гарсаар байна. Бүртгэл тооцооны цаана хүнтэй ажиллах ажлын арга, социалист уралдааныг өрнүүлэх хэлбэр, төлөвлөгөөт ажлын үр дүн байдаг учраас бүртгэл тооцоо нь үйлдвэрлэлийг удирдах чухал хэрэгшүүр болж байна.

Улс ардын аж ахуйн орчин үеийн хөгжлийн

шаардлагын дагуу бүртгэж тооцоолох, мэдээлэн судлах ажлын хэмжээ өргөжиж байгаагаас бүртгэлийн ажилтан, мэргэжилтэн нарын ажлын хүрээ, үүрэг хариуцлага улам өсч тайлан баланс, мэдээ судалгааг гаргаад орхих биш ажлын доголдол, ололт амжилтыг нь илрүүлэн зааж, эдийн засгийн гол гол үзүүлэлтүүдийн өөрчлөлтийг тодруулан тодорхой дүнгэлт хийж байхыг шаарддаг боллоо.

Бүртгэл тооцооны ажилтнуудын өмнө аймгийн тэргүүний нягтлан бодогч нарын анхдугаар зөвлөгөөн, Статистикийн алба байгуулагдсаны 50 жилийн ойг угтаж бүртгэлийн тэргүүний дэвшилтэй арга барилыг ажилдаа нэвтрүүлж, бүртгэлийн хяналт шалгалтын ролийг улам өндөржүүлэх явдал чухал байна.

Ц. БЯМБАА

ХӨДӨӨГИЙН БАРИЛГА, МАЛ АЖ АХУЙН МАТЕРИАЛЛАГ БААЗЫГ БЭХЖҮҮЛЬЕ

Хөдөөгийн барилгын талаар нам, засгаас авсан арга хэмжээний үр дүнд ХАА-н үйлдвэрлэлийн материал техникийн баазыг бэхжиж хөдөөд үйлдвэрлэл, орон сууц, соёл ахуйн барилгын ажлын хэмжээ жилээс жилд нэмэгдсээр байна.

У таван жилийн төлөвлөгөөний эхний 3 жилд аймгийн хэмжээгээр 778 хашаа барьж, 314 худат гаргаж, 53 усан сан байгуулж, ХАА-н үйлдвэрлэлийн холбогдолтой олон арван барилгууд барьж ашиглалтанд оруулжээ. Түүнчлэн ЗХУ-ын тусламжаар САА, нэгдлүүдэд ХАА-н үйлдвэрлэл, орон сууц, соёл ахуйн барилгууд баригдсан буюу баригдсаар байна.

Таван жилийн төлөвлөгөөний эхний 3 жилд аймгийн нийт хөрөнгө оруулалтын 47,0 хувийг ХАА-н үйлдвэрлэлийн материал техникийн баазыг бэхжүүлэхэд зориулж, 1974 онд 75 хувийг зарцуулахаар төлөвлөсөн нь өнгөрсөн онхоос 52,3 хувиар давжээ.

САА, ХАА-н нэгдлүүд өнгөрсөн онд 577,0 мянган төгрөгийн барилга угсралтын ажлыг өөрсдийн хүч хөрөнгөөр гүйцэтгэсний 47,6 хувийг ХАА-н үйлдвэрлэлийн зориулалттай барилга объект эзлэж байна. Ихэнх САА,

нэгдлүүд төлөвлөгөөнд тусгагдсан ХАА-н үйлдвэрлэлийн зориулалттай барилгыг барьж ашиглалтанд оруулж мал аж ахуйн материаллаг баазыг бэхжүүлж байхад Баянцогт, Борнуурын САА мал угаах суурин онгоц, Баянжаргалан сум малын хашаа, Бүрэн сум усан сан, Баян, Баянжаргалан, Бүрэн сумд тэжээл эмчилгээний цэг барих төлөвлөгөөнүүдийг тасалдуулжээ.

САА, ХАА-н нэгдлүүд барилгын өвлийн ажилд бэлтгээгүйгээс хөдөөгийн барилгын ажил улирлын шинж чанартай хийгддэг зуршил байсаар байна. Төлөвлөгөө зураг төсөвгүй барилга барих, хөрөнгийг өөр зүйлд зарцуулах явдал байгаагийн гадна барилгын чанар муу, өвөл хавар нутаглах газар ус бэлчээрийн байдлыг харгалзан бариагүй, барьсныг засч сэлбэн тордохгүй, харуул хамгаалалт тавьдаггүйгээс тоноглох, ус бороонд элэгдэж гэмтэх явдал их байна.

Сүүлийн 3 жилд гаргасан худат, барьсан хашаанаас 43,6—45,5 хувийг тэнцэх хэмжээний хашаа, худат ахилгдсан байна. Малын хашаа байрны ашиглалт, хамгаалалтыг сайжруулах зарим арга хэмжээний тухай Сайд нарын Зөвлөлийн 1971 оны 145 дугаар тог-

тоолд; Малын хашаа байрыг барьж дуусмагц сум, нэгдэл, САА-гаас томилогдсон комисс хүлээн авч, САА, нэгдлүүд өөрийн үндсэн хөрөнгийн дансанд авч паспорт бичиж хашааг эзэмшигчдэд нь хүлээлгэн өгөх, жил бүрийн 4, 5 дугаар сард малын хашаа байр бүрт үзлэг хийж ашиглалт хамгаалалтанд дүгнэлт өгөх, тухайн жил аяар засвар шаардлагатай байгааг тодорхойлон хариуцагч хүмүүсээр засуулах, мөн хашаа байрны материал, тоног төхөөрөмжийг үрэгдүүлэх, засвар үйлчилгээг тогтмол хийхгүй байгаа хөн буруутай хүмүүсийг өөрсдөөр нь хугацаа өгч засуулах буюу засварын зардлыг гаргуулж байхаар заажээ.

Иймээс энэ тогтоолын заалт нэг бүрийг САА, нэгдэл бүр мөрдөн ажиллаж, үйлдвэр, санхүүгийн төлөвлөгөөндөө тусгагдсан хүч хөрөнгөөр барих хөдөөгийн болон ХАА-н үйлдвэрлэлийн зориулалттай барилгыг батлагдсан зураг төсвийн дагуу богино хугацаанд чанар сайтай барьж мал аж ахуйн материаллаг баазыг бэхжүүлэн тасаг, бригад, фермийн төвийг тохижуулах дэс дараатай арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх нь чухал байна.

Д. АЮУШ

АРДЫН ХЯНААТЫН НУУР ТУМНИЙН ХҮҮРЦ ХАРАА

№ (2) 33

МАХН-ын Төв хороо, АХШХ болон төв байгууллагуудаас социалист эмчийн хадгалалт хамгаалалт зарцуулалтанд хийсэн үзлэг шалгалтаар манай аймгийн 200 гаруй байгууллага 600-гаад нэгж салбар 3200 хүн хамрагдан шалгагдсан юм.

Мөнгөн хөрөнгө бараа материал, мал хариуцаж байгаа 247 эд хариуцагчид гэнэтийн тооллого хийж тооцоог бодож нилээд хэмжээний дутагдал шамшигдлыг илрүүлж байгааг хохиролгүй болгох арга хэмжээг газар дээр нь авсаны гадна 722,5 мянган төгрөгийн өр авлагыг хураан авч барагдуулав. Шалгалтын дүнг БНМАУ-ын АХШХ, хуулийн төв байгууллагууд ХААЯ, ХБЯ-ны коллеги тэргүүлэгчдийнхээ хурлаар хэлэлцэж дутагдал гаргасан хүмүүст зохих арга хэмжээг авч цаашид хэрхэм ажиллах талаар тодорхой заалт өглөө.

Шалгалтыг утгаж аймгийн хэмжээгээр социалист өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, бүртгэл, тайлан тооцоо, хяналт шалгалтын ажлыг сайжруулах өр авлагыг барагдуулах, өмчийг ашиглаж

шамшигдуулахаас урьдчилан сэргийлэх, иргэдийн хууль эрхийн мэдлэгийг дээшлүүлж хариуцлагыг өндөржүүлэх талаар нилээд ажил зохиожээ.

Гэвч хөрөнгийн ашиглалт зарцуулалтыг сайжруулах үндэс анхан шатны бүртгэлийг бүтээлчээр ашиглах явдал хангалтгүй байна.

Аймгийн нийт байгууллагуын хөтөлбөл зохих бүртгэлийн 21,4 хувь нь хөтөлгөөгүй, тооллого тооцооны ажилд зарим

сум муу анхаарч иржээ. 1973 онд аймгийн хэмжээгээр тооллого хийж тооцоог нь бодох эд хариуцагчаас сараар 93, улирлаар 115, жилээр 190 хүний хариуцаж байсан хөрөнгөнд тооллого хийгээгүй байна.

Баян, Угтаал, Эрдэнэ, Эрдэнэсант, Зуунмод хотод тооллогыг тогтоосон хугацаанд нь хийгээгүй эд хариуцагч олон байлаа.

Дэлгэрхаан сумын АДХ-ын гүйцэтгэх захиргаа эд хариуцагчдын тооллого явуулахаар сүүлийн 2 жил хагаст 57 удаа

захирамж гаргаж комисс томилсон боловч тэдний ажлын гүйцэтгэлийг нэг ч удаа дүгнэсэнгүй.

Шалгалтын хугацаанд хийсэн гэнэтийн тооллогоор нярав худалдагч, кассын эрхлэгч агент зэрэг 108 эд хариуцагчаас 65,4 мянган төгрөгийн эд материал, мөнгөн хөрөнгө, мал аж ахуйн 11 суурнас 173,0 мянган төгрөгийн мал дутагдуулсан нь илрэв. Социалист өмч үрэгдэж байгаагийн шалтгаан нь хөрөнгийг бусдад зээлээр тарааж, түүнийгээ тухай бүрт нь хурааж авахгүй байгаа явдал юм.

Хүмүүсээс авах авлагын гол нь ХАА-н нэгдлүүдэд байгаа бөгөөд

хүмүүсийг хоол архиар үйлчлэх зэргээр хөрөнгө үрэгдүүлэх явдал багагүй байна.

Сүүлийн нэг жил хагасын дотор бүрэн бус судалгаагаар дийллага цайлаганд 148,0 мянган төгрөг, бэлэг дурсгалд 45,0 мянган төгрөг зарсан байна. Баян, Баянзүрх, Бүрэн, Лүн, Сэргэлэн зэрэг сумдад 70 гаруй мянган төгрөгийн хүнс материалын үнэт зүйл бэлэн мөнгийг хүмүүст зээлээр өгчээ.

Алив эд хогшил бараа материалын улсаас тогтоосон үнийг чанд баримтлах ёстой атал хотын худалдааны трест, Сэргэлэн Эрдэнэ сумдын худалдаа бэлтгэлийн ангид хутга,

чил дутагдал нь социалист өмч хөрөнгийг хамгаалан бэхжүүлэх ариунжуулах анхан шатны ба нягтлан бодох бүртгэл санхүүгийн хяналт шалгалтын талаар нам, засгаас гаргасан тогтоол шийдвэрийн заалтыг хангалтгүй биелүүлж, байгууллагын дотоодын хяналт шалгалтыг жигд сайжруулж чадаагүй болон зарим удирдах хариуцлагатан бүртгэл тооцооны ажилтан, эд хариуцагчдын ажлын хариуцлага сул, хууль эрхийн мэдлэг муугаас шалтгаалсан байна.

Иймд бүртгэл тооцоо нь ажилтан эд хариуцагчдыг ажилд авахдаа байгууллагын болон хамт олны хурлаар хэлэлцүүлж авч байх журмыг цаашид сайтар мөрдөж ажиллавал зохино.

Үзлэг шалгалтын мөрөөр илэрсэн дээрхи дутагдал зохих дүгнэлт хийж байгууллага хүмүүс гарсан дутагдлыг яаж засч ямар ажил зохиож байгаад тавих хяналт шалгалтыг газар сайгүй хүчтэй болгох нь тус аймгийн нам улс, олон нийтийн байгууллагуудын хойшлуулжгүй чухал зорилт болж байна.

Аймгийн Ардын Хянан Шалгах Хорооны хянан шалгаач
Д. БУДРАГЧАА

ҮЗЛЭГЭЭР ИЛЭРСЭН ДУТАГДЛЫГ ШУУРХАЙ ЗАСЪЯ

ЭД ХӨРӨНГИЙН ТООЛЛОГЫГ ЭРС ЧАНАРЖУУЛЪЯ

Саяхан манай аймагт эвагдсан хуулийн ба хяналт шалгалтын төв байгууллагуудын шалгалтаар тооллогын чанар хангалтгүй, комиссын бүрэлдэхүүнд эд хариуцагчдыг үзлэг хэмжээгээр оролцуулж хооронд нь сэлгүүлэн тоолуулах, комиссын ажлыг дүгнэхгүй байгаа, тооллогын бүртгэлийг нягт хянадаггүй тооцоог хайнга бодож хариуцлагагүй ханддаг дутагдал байгааг илрүүлсэн билээ.

Тус аймгийн нийт газрууд БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1968 оны 400 дугаар тогтоолыг бүрэн удирдлага болгохгүй, тооллогыг чанартай явуулахын тулд бэлтгэл ажлыг сайн хийхгүй байна. Тооллого хийхгүй буюу чанар муутай хийснээс эд хөрөнгийг идэж ашиглах үрэгдүүлж дутагдуулах зэргээр нийгэмд хохирол учруулж байна.

Заамар сумын «Заамар» нэгдлийн Ундарган бригад 5 дугаар сарын тооллогоор нэгч мал дутагдаагүй байсан боловч 20 хоногийн дараа тоолоход 300 гаруй хонь дутагдаж 59,0 мянга гаруй төгрөгийн хохирол гаргасан байна.

Тооллогын материалыг нарийн хянадаггүй, хяналт шалгалт сул байгааг

ашиглаж Борнуур сумын ХБА-ийн худалдагч Дарьханд удаа дараагийн тооллогын бүртгэлийг засварлаж, тооцоогоо бодуулж өмч хөрөнгийг идэж ашиглаж байжээ.

Түүнчлэн малыг сүвлэж шүдлэхгүй байгаагаас эр малыг эм мал болгон тоолж, ноогдол үүрэг өгөх, нас зөрүүлэх зэргээр будлиантуулах явдал гарч байгааг анхаарч тооллогыг чанартай явуулах хэрэгтэй байна.

Байгууллагын захиргаа тооллогын комиссын бүрэлдэхүүнийг сайтар боловсруулж батлан тэдэнд семинар өгч холбогдох хууль тогтоомжийг судлуулдаг байх ёстой.

Нөгөө талаар складын эмх цэгцгийг бүрэн сайжруулан барааг ярихжуулсан байхын дээр үлдэгдлийн бүртгэлийг бүрэн хөтлүүлэн складын дэвтрийг нягтлан бодогч шалгаж гарын үсэг зурсан байх шаардлагатай ба эд хариуцагчийн бүхий л баримтыг нягтлан бодогч авч боловсруулалт хийж эд хариуцагчийн гаргасан тайлантай тулгаж шалгах үүрэгтэй юм.

Тооллогын комисс нь нарийн хуваарь төлөвлөгөөтэйгөөр эд бараа нэг бүрийг нүд үзэж, малыг шүдлэх, зүслэх зэргээр тоолох ёстой.

Тооллогын бүртгэлд тоог бэллэж гаргагдахгүй болгох явдал бүрэн хогирлон, хуудас болгоны дор эд хариуцагч гарын үсэг зурсан байх ба тооллого дууссаны эцэст бүх зүйлийг тоолуулсан тухай баталгааг эд хариуцагчаас авбал зохино.

Тооллогын комисс тооллогын бүртгэлийг сайн хянаад нягтлан бодох ангид ирүүлнэ.

Гэтэл тооллогын материалыг эд хариуцагчдад өгдгөөс бүртгэлийн материалыг будлиантуулж өөрчлөх явдал гарсаар байна. Мөн комисс удаан хугацаагаар эдлэгдэж чанар байдлаа алдагдаж, эвдэрч хэмхэрсэн зэргээр актаж устгах зүйлийг нарийн үзэж тусгайлан бүртгэж акхлах саналаа байгууллагат гаргаж өгөх ёстой. Гэтэл акталсан зүйлийг устгадаггүй олон жил болгосноо тооллого будлиантаж эд материал нилүүдэх эсвэл дутах явдал гардгийг анхаарвал зохино. Тооллогын комиссын материалыг нягтлан бодогч хүлээн авмагч орлого зарлагыг бараа материалын нэр төрлөөр тулган шалгаж тооцоог бодож акт тогтоон нилүүдсэн, дутагдсан үйлдэл гарвал актыг дагуу нягтлан бодох бүртгэлд тусгаж байх нь зүйтэй.

Д. ТӨМӨР

хайч, шугам, сэрээ, хүүхдийн цамц зэрэг нилээд барааг улсын жижиглэн худалдаалах үнээс дээгүүр үнээр худалдаж байсан нь шалгалтаар илэрчээ.

Түүнчлэн худалдаа бэлтгэл ба хөдөө аж ахуйн байгууллагуудад бэлтгэгэлийн зүйлд анхан шатны тордолт муу хийж байгаагаас чанарыг доройтуулах, аймгийн Барилга угсралтын контор барилгыг чанар муутай барих, хугацааг удаашруулах зэрэг хариуцлагагүй хандсан дутагдлууд гарч байв.

Шалгалтаар илэрсэн зөр-

ТОГТООЛЫН МӨРӨӨР

Баянцогтын САА-н дэргэдэх ардын хянан шалгах группын ажлын тухай аймгийн АХШХ-ны хурлаар 1973 онд хэлэлцэж тодорхой заалт бүхий тогтоол гаргасан юм.

Уг тогтоолд тэмдгэлэгдсэн дутагдлыг арилгаж, группийн ажлыг сайжруулахын төлөө тус групп ажлаа нарийн төлөвлөн ажиллаж хяналт шалгалтын ажлын үр нөлөөг дээшлүүлэн төлөвлөн ажлаа бүрэн биелүүлэх зорилт тавьснаа хэрэгжүүлж байна.

Архи уух, ажил таслах, даалгасан ажлыг үл биелүүлэх явдал нилээд хэмжээтэй байсан 2-р тасагт АХШГ-ийн шалгалтыг хийж уг асуудлыг газар дээр нь хэлэлцүүлсэн нь зохих үр дүн өгч тасгийн хамт олны ажил урьдаас сайжирсан байна.

Хяналт шалгалтыг аль болохоор олон хүний бүрэлдэхүүнтэй хийх нь асуудлыг тал бүрээс нь харьцангуй талтай учир цаг үеийн ажлуудад хэд хэдэн хүнтэй хянаагчдын группүүд ажилууд даг байна.

Тэдгээрээс үр дүнтэй сайн ажилласан хянан шалгагчийг урамшуулан шагнаж байна.

Төлийн тооллого явуулах, малыг сүвлэж тоолох

ажилд тэргүүний малчдыг оролцуулсан нь шалгалтын нэр хүнд үр нөлөөнд сайн үр дүн үзүүлжээ.

Адууг сүвлэн тоолж үзэхэд олон тооны гүүгэр сувай малд тоолж байсныг илрүүлэн засч цаашид адууг манаатай болгож, бүртгэл тооцоог тодорхой болгожээ.

Худалдаа бэлтгэлийн анги дээр хийсэн шалгалтынхаа мөрөөр ном борлуулах ажил зохиож малчдын номын санд номын нэрсийн жагсаалт гаргаж өгөх зэргээр ажиллажээ. Эдгээр арга хэмжээний дүнд шаардах хуудас өгөлтийн тоо цөөрч талархлын хуудас олголт 10 гаруй болж өсчээ.

Гэвч аливаа ажлыг жигд харж доголдож буй ажлыг засч байхад хангалтгүй анхаарсан дутагдал байгааг Гүнын фермд малын хашааг муу эзэмшиж байсан ноцтой дутагдал оршиж байхад түүнийг илрүүлэн арилгаж чадаагүй явдал нотолж байна. Иймд хяналтын ажлыг хавтгайруулан үр дүн баттай явуулахаас аль болохоор сэргийлж, дутагдалын голыг олж илрүүлэн түүнийг эрчимтэй засаж байхад хяналтын ажлын чухал зорилт оршино.

МАНАЙ СУРВАЛЖЛАГЧ

УРЛАГ СПОРТЫН НӨХӨРСӨГ УУЛЗАЛТ

Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын төвд тус аймгийн Эрдэнэсант, Өвөрхангай аймгийн Сант сумдын клубийн туршлага солилцох урлагийн тоглолт, биеийн тамирын тэмцээн болов.

Бүсийн уулзалтанд Эрдэнэсант сум уран сайханд чадвартай зохион байгуулж Буриад АССР-ийн зохиолч Шагжийн Цэвэргийн зохиол «Миний бэр» драмын жүжиг, концерт бэлтгэж оролцов.

Мөн аймаг сумаа сурталчилсан булан самбар үзүүлэн, сүү цагаан идэний үзэсгэлэн нээж ажилуулав.

Өвөрхангай аймгийн Сант сум уран сайханд чадвартай зохион байгуулж, Дундговь аймгийн Эрдэнэдалай сум Дождоодоржийн зохиол «Алхам» гэдэг драмын жүжиг, концерт бэлтгэж тоглов.

Энэ уулзалтаар явагдсан эрэгтэйчүүдийн гар бөмбөгийн тэмцээнд Өвөрхангай аймгийн Ойдов ахлагчтай баг, эмэгтэйчүүдийнхэд Төв аймгийн Эрдэнэсант сумын Цэнд ахлагчтай баг, эрэгтэйчүүдийн шатрын тэмцээнд Эрдэнэсант сумын Адыадорж, эмэгтэйчүүдийнхэд Сант сумын Тогооч, одон бөмбөгөнд эрэгтэйчүүдээс Эрдэнэдалай сумын Чандалдорж эмэгтэйчүүдээс мөн сумын Буянтгогтох түрүүлж, үндэсний бөхөд Дундговь аймгийн

Эрдэнэдалай сумын жоооч аймгийн начин Бадарчин түрүүлж Өвөрхангай аймгийн Сант сумын харьяат цэргийн арслан Самдан үзүүлэв.

Дээрх тэмцээний дүнгээр Дундговь аймгийн Эрдэнэдалай сум 11 оноогоор 1 дүгээр байр, Өвөрхангай аймгийн Сант сум 16 оноогоор 2 дугаар байр, Төв аймгийн Эрдэнэсант сум 18 оноогоор 3 дугаар байр эзлэв.

Урлагийн тоглолтоор Төв аймгийн Эрдэнэсант сумын концерт, «Манай бэр» жүжиг, Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын үзэгдэлт концерт «Алхам» жүжиг өндөр үнэлэлт авлаа. Энэхүү урлаг спортын уулзалтад МАХН-ын III их хурал хуралдсаны болон БНМАУ-ыг тунхагласны 50 жилийн ой угтсан бүх ард түмний урлагийн бүх шатны үзэлт тус гурван сумаас шалгарсан урлагийн авьяастнууд оролцсон нь сумын клубээс малчид хөдөлмөрчдийн дунд зохиох соёл хүмүүжил, урлагийн ажлын талаарх арга туршлагаа харилцан солилцсон чухал ач холбогдолтой боллоо.

Цаашид энэ мэт, туршлага солилцох уулзалтыг нийт сумдын клубээс үе үе зохиож байх нь чухал байна.

Н. СОДНОМХҮҮ

Грузины дуу бүжгийн чуулга



Грузины дуу бүжгийн «Салхино» чуулгийн урьсанд ардын дуу бүжиг зохиолдог. Тус хамтлагийнхан Софи хотноо болсон дэлхийн залуучууд оюутны IX их наадамд оролцож ардын уламжлалт бүжгээрээ алтан медаль хүртжээ.

ЗУРАГ ДЭЭР: Тус чуулгийн гоцлол бүжигчин Манана Маравелидзе



Тус чуулгийнханы бүжсэн «Салэнт» бүжгийн хэсэг



Эмэгтэй бүжигчдийн хэсэг «Хуриман бүжиг» бүжиг байгаа нь

ТАСС-аас ирүүлсэн гэрэл зураг

Ариун цэврийн сарын ажил

Говь-алтай аймгийн нийгмийг аюулаас хамгаалах хэлтсийн сарын ажлыг С. Норов ариун цэврийн орон тооны бүс байцаагчаар 3 жил ажиллаж байгаа бөгөөд Алтай хотын ариун цэвэр, соёлжилтыг дээшлүүлэхийн тулд хариуцсан нутаг дэвсгэрийнхээ айл өрх нэгдсэн байр гадаад дотоод орчныг тохижуулах, их бага цэвэрлэгээг хийлгэх, бие засах газар, бохир усны цооног, хашааг шинэчлэн байгуулах ажилд хөдөлмөрчдийн хүчийг нэгтгэн зохион байгуулж үлгэр жишээгээр оролцуулдаг байна.

Хариуцсан байгууллага айл өрхүүдэд ариун цэврийн үзлэг шалгалт, суртал ухуулгын ажил явуулахдаа 10 гаруй нэр төрлийн үзүүлэн таниулах материал ашигладагас гадна шалгалтаар илэрсэн ариун цэвэрч соёлч боловсон айл өрхийн ажиллагааг бусдад сурталчилж эзэмшүүлэх, хоцорч яваа айл өрх хүн амд холбогдох хууль дүрмээс ярьж ариун цэвэрч байхын ач холбогдлын тухай ойлгуулан, шаардагдах зүйлүүдийг хийлгэж,

олот дутагдлыг бодит байдлаар харуулсан самбар материал ашиглан үнэмшүүлэх, жигшүүлэх аргыг хослон хэрэглэдэг байна. Өөрийн хариуцсан нутаг дэвсгэрийн айл өрхөд ариун цэвэр, соёлжилтын судалгааг 50 гаруй нэр төрлийн зүйл дээр хийснийг үзэхэд бүх өрхийн 73 хувь нь гоо-жуурт угаагуур, ариун цэврийн булантай болжээ. Айл өрхийн соёлжилтын барааны хүрэлцээ,

СЭРГИЙЛЭГЧ БАЙЦААГЧ

хангамжийг судлан хөдөлмөрчдийн санал хүсэлтийг авч холбогдох байгууллагад уламжлан ариун цэвэр соёлжилтын байдлыг дээшлүүлэхэд судалгаа дүгнэлт гарган ажилладаг юм.

С. Норов ариун цэвэрч гэгээрлийн сурталчилгаа зохиохдоо хэсэг хариуцсан их бага эмч, сувиллагч нараас мэргэжлийн зөвлөлгөө авч айлдөрхөөр

хамт явж сурталчилгааны чанар үр нөлөөг дээшлүүлэхийн тулд газар дээр нь зааж сургах аргыг өргөн ашиглаж байна.

Хариуцсан албан байгууллага, айл өрх бүрт ариун цэврийн дэвтэр нээж илэрсэн дутагдлыг бичиж, шаардах хуудас егч биелэлтийг шалгаж тэмдэглэдгээс гадна хашаа гудамж нэгдсэн байруудад эргүүл дежурыг томилж ажил хүлээлэх дэвтэр бий болгон хөтлөж, тэргүүний байранд шилжин явах дарцаг агуулдаг байна.

Орон сууц, нийтийн байр, гудамж хэсгийн ариун цэврийн комиссын ажлыг сард 1-ээс доошгүй удаа шалган зааварлаж комиссуудыг хооронд нь уралдаантай ажиллуулан ажлыг нь дүгнэдэг байна.

Тэргүүний ариун цэврийн комиссын ажиллагааг бусдад сурталчлах эзэмшүүлэх ажил зохиолдог зэрэг ажил нь төр нутаг дэвсгэрийн айл өрхийн соёлжилтонд чухал нөлөө үзүүлдэг болжээ.

Б. ХИШИГТ

Цай уух зуур

Шинжлэх ухаан тэхникийн хувьсгалын эрин үед минутын үнэ цэнэ улам их болжээ.

Коммунизмын орон ЗХУ нэг минутанд 400 морины хүчтэй трактор 5, ачааны ба суудлын автомашин 9, автомат төхөөрөмж болон багаж хэрэгсэл 45 мянгат тус тус үйлдвэрлэж байна.

Манай гаригийн оршин суугчид 1950 оноос 1970 он хүртлэх хугацаанд 1 миллиард 255 саяар өсчээ. Одоо дэлхийн хүн ам өдөрт 200 мянгаар нэмэгдэж байгаа аж.

Дэлхийн бүх даасны 98 хувийг модноос гаргал авдаг.

Түлшний 1 шоо метр модноос 200 кг целлюлоз гаргаж авах ба түүгээр 1500 метр торго буюу 4000 хос торгон оймс хийдэг гэнэ.

Мөн 1 шоо метр модноос 70 литр архины спирт гаргаж авдаг байна.

Хүн хоногт 13 шоо

метр агаараар амьсгадаг ба энэ нь хоногт хэрэглэх хоолноос 10 дахин их байдаг гэнэ.

1974 оны 2 дугаар сарын 1-ний байдлаар манай улсын хүн ам 1377.9 мянга байгаагийн дотор 40 гаруй хувийг нь 16 хүртлэх насны хүүхэд залуучууд эзлэж байна.

Эдүгээ тус улсад 272 нэгдэл, 32 сангийн аж ахуй, ерөнхий боловсролын 547, тусгай мэргэжлийн 19, дээд 5 сургууль, 529 цэцэрлэг ажиллаж байна. Тус орны 10000 хүн тутмаас 2200 нь буюу дөрвөн хүний нэг нь ямар нэг сургуульд суралцаж байна. Одоо улс орны хэмжээгээр 20 мянган зурагт радио, 110 мянган радио хүлээн авагчаар үндэсний программ нэвтэргэгдэж байна. Хүн ардын эрүүл энхийн төлөө 67 больниц, их бага эмчийн 1069 салбар мөн олон арван поликлиник диспансер, амбулатор, түргэн тусламжийн станц үйлчилж байна.

Б. ЦЭРЭНДАШ

ХАРИУЦЛАГАТАЙ ЭРХЛЭГЧ

Д.ТОВУУ

Зарлал

Баянжаргалан сумын харьяат Аюуш овогтой Жамц нь иргэний 314290 тоот үнэмлэхээ гээгдүүлсэн тул хүчингүйд тооцов.